



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 4.1.2-т заасныг тус тус үндэслэн Цөмийн энергийн комиссоос ТОГТООХ нь:

1. Хавдар судлалын үндэсний төвд хэрэгжиж буй Олон улсын атомын энергийн агентлагийн “Шугаман хурдасгуурт суурилсан стереотактик туяа эмчилгээний аргыг нэвтрүүлж, түгээмэл тохиолддог хорт хавдрын эмчилгээний чанарыг сайжруулах нь” төслийн хэрэгжилтийн хүрээнд төвийн мэс засал, туяа эмчилгээний үйлчилгээг өргөтгөхөд шаардлагатай “Хорт хавдрын мэс засал ба туяа эмчилгээг дэлхийн жишигт хүргэж, төвлөрлийг сааруулах үйл ажиллагаанд шаардагдах багаж, тоног төхөөрөмжийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

2. Хавдар судлалын үндэсний төвийг хавсралтад заасан багаж тоног төхөөрөмжөөр хангах зардлыг үе шаттай улсын төсөвт тусгаж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн яам /С.Энхболд/-нд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба /Г.Манлайжав/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
КОМИССЫН ДАРГА



 П.ОЮУН-ЭРДЭНЭ

Цөмийн энергийн комиссын
2021. оны 07 сарын 08. өдрийн... хуралдааны
01.. дугаар тогтоолын хавсралт

**ХОРТ ХАВДРЫН МЭС ЗАСАЛ БА ТУЯА ЭМЧИЛГЭЭГ ДЭЛХИЙН ЖИШИГТ
ХҮРГЭЖ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ
БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЭЛ**

№	Тоног төхөөрөмжийн жагсаалт	Тоо ширхэг	Төсөв /Евро/
1. ХОРТ ХАВДРЫН РОБОТ МЭС ЗАСЛЫН ТӨВ БАЙГУУЛАХ			
1.	Роботик мэс заслын Da Vinci Xi аппарат	1	1,300,000
2.	Philips CX50 хэт авиан аппарат	1	
2. ТУЯА ЭМЧИЛГЭЭГ ДЭЛХИЙН ЖИШИГТ ХҮРГЭХ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ			
2.1 Стереотактик туяаны мэс засал хийх нөхцлийг цогцоор бүрдүүлэх			
1.	Тархи нугасны хавдрын стереотактик туяа эмчилгээ хийх дүрслэлийн тоног төхөөрөмж, EXACTRAC Dynamic төлөвлөлтийн систем	1	1,500,000
2.	Амьсгалын хөдөлгөөнийг зохицуулан туяа эмчилгээний төлөвлөлтийг КТГ-ийн зургийг авах хүчин чадалтай 4 хэмжээст өргөтгөл бүхий компьютер томографт симулятор	1	700,000
2.2 Баруун бүсийн туяа эмчилгээний төв байгуулах			
1.	Энгийн симулятор, телекобальтын бункер барих	1	1,000,000
2.	ХСҮТ-өөс энгийн симулятор, телекобальтыг нүүлгэн суурилуулах	1	
3.	Баруун аймгийн бүсийн оношлогооны төвийн компьютер томографи аппаратад лазерын систем, орны тэгш тавцанг суурилуулах	1	
4.	3 хэмжээст физик төлөвлөлтийн CMS XiОсистемийг нүүлгэн суурилуулж Баруун аймгийн бүсийн оношлогооны төвийн компьютер томографитай DICOM- оор холбох	1	
5.	2 хэмжээст төлөвлөлтийн систем шинээр худалдан авах	1	
6.	Цацрагийн чанарын хяналтын багаж худалдан авах	1	
7.	Боловсон хүчнийг бэлтгэх (туяа эмчилгээний эмч -2, эмнэлгийн физикч-1, техникч-2, тоног төхөөрөмжийн инженер-1)	6	
2.3 MRI дүрслэлд суурилсан дотуур туяа эмчилгээний иж бүрэн нэгж байгуулах			
1.	Дотуур туяа эмчилгээний Со-60 үүсгүүртэй аппарат, физик төлөвлөлтийн систем, MRI/CT тохиромжтой аппликатор, бункерын тохижилт	1	500,000
Нийт төсөв (Евро)			5,000,000